



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 83

Мандалговь

Г

7

С.Амарбаярыг албан тушаалд нэр
дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Сайнбилэгийн Амарбаяр 67.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.


Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа С.Амарбаярын санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



330821051

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2020 оны 6 дугаар сарын
15.. -ны өдрийн 89 дүгээр тогтоолын хавсралт



**Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн хамгааллын
хяналтын улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн
Сайнбилэгийн Амарбаярын тухай дүгнэлт**

1. С.Амарбаяр нь 1986 онд Завхан аймгийн Улиастай сумын төвд төрсөн. 34 настай. Эрэгтэй.
2. Боловсролын байдал: Монгол улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийг 2003-2007 онд бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Санхүү, эдийн засаг мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 2007-2014 онд Аудитын газар шинжээч, 2014-2015 онд Иргэний харьяатын шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт дотоод аудитор, 2018 онд Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газарт нийгмийн хамгааллын байцаагчаар ажиллаж байсан.
4. С.Амарбаярын төрийн захиргааны албанад ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ